



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 01 сарын 04 өдөр

Дугаар А/03

Улаанбаатар хот

Коронавируст халдварын хяналт, сэргийлэлт,  
бэлэн байдал, хариу арга хэмжээг эрчимжүүлэх тухай.

Улсын онцгой комиссын 2021 оны 01 дүгээр албан даалгавар, Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссоос өгсөн үүрэг чиглэлийн дагуу Мэргэжлийн хяналтын байгууллагаас хийсэн хяналт шалгалтын зөвлөмж, НЭМГ-ын даргын 2021 оны 01 сарын 01 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх, коронавируст халдварын хяналт, сэргийлэлт бэлэн байдал, дэгдэлтийн үед ажиллах хариу арга хэмжээг эрчимжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. Шуурхай хариу арга хэмжээний багийн төлөвлөгөөний тодотголыг нэгдүгээр хавсралтаар, Коронавируст халдварын хяналт, сэргийлэлт, бэлэн байдал, дэгдэлтийн үед ажиллах хариу арга хэмжээг эрчимжүүлэх, зөрчил дутагдлыг арилгах 10 хоногийн аяны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Энэхүү тушаалын 1,2 дугаар хавсралтаар батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг шуурхай штабын гишүүдэд үүрэг болгосугай.
3. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад шаардагдах зардлыг гаргахыг ерөнхий нягтлан бодох /С.Оюунцэцэг/-т зөвшөөрсүгэй.
4. Энэ тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг штабын дарга /Б.Лувсанням/-д даалгасугай.

ДАРГА

Э.БОДЬЦЭЦЭГ

БАТЛАВ:  
 ХАН-УУЛ ЭРХИМ МЭНДИЙН ТӨВИЙН  
 ДАРГА  
 Э.БОДЬЦЭЦЭГ

ШУУРХАЙ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ БАГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОДОТГОЛ

2021 оны 01 сарын 04-ний өдөр

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах албан тушаалтан	Дэмжлэг үзүүлэх мэргэжилтэн
Нэг.	Коронавируст (Ковид-19) халдварын цар тахлын батлагдсан болон сэжигтэй тохиолдолд авах арга хэмжээ			ЭМ-ын албаны дарга
1	Шуурхай хариу арга хэмжээний багийг дуудлагын схемийн дагуу дуудаж ЭМТ-н эмнэлгийн шуурхай штабын өрөөнд цуглуулах.	25 минут	Шуурхай хариу арга хэмжээний баг	Э.Бодьцэцэг Штабын дарга Б.Лувсанням
2	Сэжигтэй тохиолдолын зураглалыг гарган үзлэг оношилгоо хийн яаралтай шинжилгээнд хамруулан оношийг баталгаажуулах	60 минут	Шуурхай хариу арга хэмжээний баг	Шинэ болон сэргэж буй халдварын хариуцсан ажилтан С.Өлзийжаргал
3	Халдварын-сэжигтэй болон батлагдсан тохиолдлын ойрын хавьтлыг сорьц авч шинжлэх багийг томилгох, арга зүйгээр хангах	2 цаг	Шуурхай хариу арга хэмжээний баг	Штабын дэд дарга Т.Гэрэлсүрэн
4	Хэвтэн эмчлүүлэх тасгийн бэлэн байдлыг яаралтай ханган, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг нягтлан шалгах.	2 цаг	Шуурхай хариу арга хэмжээний баг	Штабын дарга Б.Лувсанням
5	Ойрын хавьтлыг ажиглан тусгаарлах байрны бэлэн байдлыг ханган байрлуулах үйл ажиллагааг зохион байгуулах	2цаг	Шуурхай хариу арга хэмжээний баг	Штабын дарга Б.Лувсанням
6	Коронавируст (Ковид-19) халдварын сэжигтэй болон эмнэлзүйн хөнгөн хэлбэрийн шинж тэмдэг илэрсэн хүнийг ЭМС-ын А/247 дугаар тушаалын дагуу гэрээр хянах.	24 цаг	Шуурхай хариу арга хэмжээний баг	Шинэ болон сэргэж буй халдварын асуудал хариуцсан ажилтан

2	Иргэд эрүүл мэндийн байгууллагад хандан нарийн мэргэжлийн эмчээс 11342003, 70049252, 341003 утсаар зөвөлгөө тусламж авах	24 цаг	Шуурхай хариу арга хэмжээний баг	Мэргэжлийн ангийн бэлэн байдал хариуцсан ажилтан Ц.Тулга Мэдээллийн ажилтан А.Амартөвшин
3	Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нар гар утсаа цахим хаягт байршуулан өөрсдийн харъяалах иргэдэд эрүүл мэндийн зөвөлгөө тусламжийг утсаар өгөх.	24 цаг	Шуурхай хариу арга хэмжээний баг	Штабын дарга Б.Лувсанням
4	Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нар цар тахлын улмаас хөл хорио болон тусгаарлалтад байгаа эмзэг бүлгийн иргэд тухайлбал асран хамгаалах харгалзан дэмжих хүнгүй хүүхэд эмэгтэйчүүд, өндөр настнуудад сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх	24 цаг	Шуурхай хариу арга хэмжээний баг	Штабын дарга Б.Лувсанням
5	Жирэмсэн болон төрөх дөхсөн эмэгтэйчүүд, хавдартай, чихрийн шижин, ахмад настнуудын яаралтай тусламж авах шаардлагатай өвчтөнүүдийн судалгааг үе шаттай шинэчлэн гаргаж ажиллах	24 цаг	Шуурхай хариу арга хэмжээний баг	Штабын дэд дарга Т.Гэрэлсүрэн
6	Эмнэлгийн ажилтанг халдвараас сэргийлэх, эмнэлгийн дотоод халдвар гархаас сэргийлэн ажиллаж эрүүл мэндийн ажилтанд нэг удаагийн хамгаалах хувцас хэрэглэл өмсөх, тайлах дадлага тогтмол хийлгэх.	24 цаг	Шуурхай хариу арга хэмжээний баг	Шинэ болон сэргэж буй халдварын асуудал хариуцсан ажилтан С.Өлзийжаргал Мэргэжлийн ангийн бэлэн байдал хариуцсан ажилтан Ц.Оюунчимэг
7	Эмнэлгийн ажилтанг халдвараас сэргийлэх, эмнэлгийн дотоод халдвар гарахаас сэргийлэн ажиллаж үйлчлэгч нарын цэвэрлэгээ үйлчилгээнд дотоодын хяналт сайн хийж мэргэжил арга зүйн зөвөлгөө өгөн ажиллах.	24 цаг	Шуурхай хариу арга хэмжээний баг	Шинэ болон сэргэж буй халдварын асуудал хариуцсан ажилтан С.Өлзийжаргал Мэргэжлийн ангийн бэлэн байдал хариуцсан ажилтан Н.Оюунмэд

8	Эмнэлгийн хог хаягдал хаях, устгах ажиллагаанд хяналт тавин ажиллах.	24 цаг	Шуурхай хариу арга хэмжээний баг	Шинэ болон сэргэж буй халдварын асуудал хариуцсан ажилтан С.Өлзийжаргал
9	Зурагт болон цахим сүлжээгээр дотор, хүүхэд, эмэгтэйчүүд, хавдар, ахмад настны эмч нарын зөвлөгөө мэдээлэл явуулах	24 цаг	Шуурхай хариу арга хэмжээний баг	Штабын дарга Б.Лувсанням Мэдээлэл хариуцсан ажилтан А.Амартөвшин
10	Эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардлагатай бүх төрлийн нөөцөд хяналт тавин ажиллах	24 цаг	Шуурхай хариу арга хэмжээний баг	Штабын дарга Б.Лувсанням Албаны ар тал хариуцсан ажилтан С.Оюунцэцэг
11	Хүний нөөцийн бэлэн байдлыг ханган эмнэлгийн ажилтны дархлааг дэмжин ажил амралтыг зохицуулан хүний нөөцөө зөв хувиарлан ажиллах	24 цаг	Шуурхай хариу арга хэмжээний баг	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан Ц.Энхбаясгалан

Хан-Уул эрүүл мэндийн төвийн даргын  
2021 оны ..... сарын .....-ний өдрийн  
..... тоот тушаалын хавсралт

**Коронавируст халдварын хяналт, сэргийлэлт, бэлэн байдал, хариу арга хэмжээг эрчимжүүлэх, зөрчил дутагдлыг  
арилгах 10 хоногийн аяны хүрээнд хийх ажлын төлөвлөгөө**

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах тасаг нэгж, албан тушаалтан	Хяналт тавих албан тушаалтан
<b>Нэг. Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр :</b>				
1	Үүссэн нөхцөл байдалтай уялдуулан авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний зураглалыг үйл ажиллагаа бүрээр гаргах, эмнэл зүй, тандалт, дэмжих үйлчилгээний багуудыг тушаалаар томилон үүрэгжүүлэх	1 сарын 4	НЭМО дарга Б.Лувсанням	ХУЭМТ-ийн дарга Э.Бодьцэцэг
2	Коронавирусын халдварын үед ажиллах хүний нөөцийн судалгаа болон хүний нөөцийн дутагдалтай үед нөхөж ажиллах, гаднаас татан ажиллуулах эмч, мэргэжилтний судалгааг тус тус гарган ажлын чиг үүргийг танилцуулан мэдээлэл өгөх, гарын үсэг зуруулж баталгаажуулах	1 сарын 4	Хүний нөөцийн албаны дарга Ц.Энхбаясгалан	ЭЭО Дарга Т.Гэрэлсүрэн
3	Коронавирусын халдварын үед цагийн байдалд тохируулан, төлөвлөгөөний дагуу нийт эмч, эмнэлгийн мэргэжилтэн, албан хаагчдад халдварын үеийн авах арга хэмжээний чиглэл болон хувийн хамгаалах хэрэгсэл өмсөж тайлах дадлага сургуулийг тогтмол хуваарийн дагуу явуулж, ажил үүргийг тодорхой болгон дадлагаажуулах	Өдөр бүр	Сувилахуйн албаны дарга Б. Халиунгэрэл Чанарын менежер Ц.Оюунчимэг	ЭЭО Дарга Т.Гэрэлсүрэн
4	Коронавирусын халдварын үед эмнэлгийн ор дэлгэх, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг тодотгож зураглал гаргах	1 сарын 5	Хэвтэн эмчлүүлэх тасгийн эрхлэгч Ц. Гэрэлт-Од	ЭЭО Дарга Т.Гэрэлсүрэн

Хоёр. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр:		1 сарын 5	Эм зүйч Б.Ариунзүл Тоног төхөөрөмжийн инженер Ж.Баянбаатар	ЭЗОДарга Т.Гэрэлсүрэн
5	Эм , эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн судалгааг бодитойгоор тооцон гаргаж бэлэн байдлыг хангах	1 сарын 8	Мэдээлэл технологийн албаны дарга А.Амартөвшин	НЭМОДарга Б.Лувсанням
6	Эмнэлгийн эрсдэл бүхий газруудад камер байрлуулж дотоод холбоотой зарлан мэдээллийн системтэй болох / тусгаарлах өрөө, шар бүс, молекул биологийн лаборатори /	Өдөр бүр	Төв салбарын эрхлэгч Г.Цолмон, Салбар амбулаторийн эрхлэгч Г.Оюунцэцэг, Хэвтэн эмчлүүлэх тасгийн эрхлэгч Ц.Гэрэлт-Од	НЭМОДарга Б.Лувсанням
7	Эмнэлгийн бүх хэсэгт бөөгнөрөл үүсгэхгүй байх, зай барих, маск зүүх, гар халдваргүйжүүлэх онцгой дэглэмийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах	Өдөр бүр	Тоног төхөөрөмжийн инженер Ж.Баянбаатар	Чанарын албаны дарга Н.Оюунмэд
8	ЭМТ-д ашиглагдаж байгаа бүх тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгслийн ашиглалт, бэлэн байдал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг бүрэн байрлуулж ашиглалтын паспортыг бүрэн хөтөлсөн эсэхэд хяналт шалгалт хийх	Өдөр бүр	Төв салбарын эрхлэгч Г.Цолмон, Салбар амбулаторийн эрхлэгч Г.Оюунцэцэг, Хэвтэн эмчлүүлэх тасгийн эрхлэгч Ц.Гэрэлт-Од	Чанарын албаны дарга Н.Оюунмэд
9	Коронавирусын халдвартай өвчтөнийг хугацаа алдахгүй илрүүлэх, бусад үйлчлүүлэгчтэй холихгүй, халдварыг тархаахгүй байх зорилгоор эрэмбэлэн ангилалт хийж ЭМС-ын А/562 дугаар тушаалыг хэрэгжүүлэх ажиллах	Өдөр бүр	Сувилахуйн албаны дарга Б.Халиунгэрэл Чанарын менежер Ц.Оюунчимэг	Чанарын албаны дарга Н.Оюунмэд
10	Холбогдох тушаал, шийдвэрийн дагуу тандалт судалгааг тогтмол хийх, тархвар судлалын асуумжийг авахдаа өмнө бүртгэгдсэн тохиолдлыг судлан тодорхой кейсүүд оролцуулах, эрт илрүүлэх, оношлох чиглэлээр эрүүл мэндийн ажилтан бүрийг тасралтгүй сургах	Өдөр бүр	Жолооч, ариутгагч нар	Тархвар судлаач С.Өлзийжаргал
11	Түргэн тусламжийн машины тээвэрлэлт хооронд цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг заавар журмын дагуу тогтмол хийж хяналт тавьж ажиллах	Өдөр бүр		

12	Байгууллагын бүх хэсэгт тодорхой хуваарийн дагуу халдваргүйтгэл хийх, гадаргуу халдваргүйжүүлэгч бодисыг үзлэг, эмчилгээний цэгт байршуулж тогтмол хэвших	Өдөр бүр	Тархвар судлаач С.Өлзийжаргал	Чанарын албаны дарга Н.Оюунмэд
13	Эмнэлгийн тусламж үйлчилгээнээс үүсч буй хог хаягдлыг ангилан хадгалах заавар журмын дагуу төрөлжүүлэн цуглуулж түр хадгалан, устгалын байгууллагад хүлээлгэн өгч бүртгэл тэмдэглэл тогтмол хөтлөх, аюултай хог хаягдлын аюулгүй ажиллагааны зааварчилгааг боловсруулан гарган баталж мөрдөж ажиллах	Өдөр бүр	Хог хаягдал хариуцсан ажилтан	Тархвар судлаач С.Өлзийжаргал
14	Эмнэлгийн ажилтан, үйлчлүүлэгчдэд зориулсан ариун цэврийн өрөөний эмх цэгц, цэвэрлэгээ, халдваргүйтгэлд анхаарч, гар угаах нөхцөл бололцоог бүрэн бүрдүүлэх	Өдөр бүр	Тархвар судлаач С.Өлзийжаргал	Чанарын менежер Ц.Оюунчимэг
15	ЭМТ-ийн QR кодыг хэвлэн байршуулж, үйлчлүүлж буй иргэд бүрээр уншуулж, эрэмбэлэн ангилж оруулах	Өдөр бүр	Хөтөч ажилтан	Төв салбарын эрхлэгч Г.Цолмон, Салбар амбулаторийн эрхлэгч Г.Оюунцэцэг
<b>Гурав. Эм, эмнэлгийн хэрэгслийн хангалт, хадгалалт, хамгаалалтын чиглэлээр :</b>				
16	Эмчилгээ үйлчилгээнд хэрэглэж буй эм, эмнэлгийн хэрэгслийн хугацаа, хадгалалтын горим, хэрэглээнд хяналт тавьж эм, эмнэлгийн хэрэгсэл хадгалж буй өрөө бүрт өрөөний чийглэг болон дулаан хэмжигчийг байрлуулж, хадгалалтын нөхцөлийг тогтмол хянаж бүртгэх, тасалгааны хэм, чийглэгийг стандартын шаардлагад нийцүүлэх	Өдөр бүр	Эм зүйч Б.Ариунзул	Чанарын менежер Ц.Оюунчимэг
17	Коронавирусын халдварын дэгдэлтийн үед хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэх, хувийн хамгаалах хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодисын нөөцийг эмнэлгийн бүх ажилтан, албан хаагчийн тоо, хэрэглээтэй холбон бодитойгоор тооцож гаргах	Өдөр бүр	Эм зүйч Б.Ариунзул	ЭЭОДарга Т.Гэрэлсүрэн НЭМОДарга Б.Лувсанням

18	Хувийн хамгаалах хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодис, эм, эмнэлгийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хадгалалтын горимд хяналт тавьж зааврын дагуу эмх цэгцтэй төрөлжүүлэн ангилж хадгалах, багцалж бэлтгэх, хувийн хамгаалах хэрэгслийг эмнэлгийн ажилтан бүрт хүрэлцэхүйц хэмжээгээр олгон хүлээлгэн өгсөн тухай бүртгэлийг олгосон хугацаа, нэр төрөл, тоо ширхэгээр бүртгэж, гарын үсгээр баталгаажуулах	Өдөр бүр	Эм зүйч Б.Ариунзул Тархвар судлаач С.Өлзийжаргал	Чанарын менежер Ц.Оюунчимэг
19	Улсын бүртгэлд бүртгэгдсэн тухайн онд хэрэглэх химийн бодисын жагсаалтаар хэрэглэхийг зөвшөөрөгдсөн бодисыг заавар, журмын дагуу хэрэглэж түүнд тавих дотоодын хяналтыг сайжруулах	Өдөр бүр	Чанарын менежер Ц.Оюунчимэг Эм зүйч Б.Ариунзул	Чанарын албаны дарга Н.Оюунмэд
<b>Дөрөв. Мэдээлэл, сургалт, сурталчилгааны чиглэлээр :</b>				
20	Коронавируст /КОВИД-19/ халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах чиглэлээр мэдээ, мэдээлэл, сэрэмжлүүлэг, ухуулах хуудас зэргийг бэлтгэн иргэдэд байнгын давтамжаар хүргэх	Өдөр бүр	Сургалт хариуцсан менежер О. Ууганбаяр	НЭМОДарга Б.Лувсанням
21	Коронавирусын халдвартай тэмцэх, сэргийлэх чиглэлээр гарсан тушаал шийдвэрүүдийг үйл ажиллагааны онцлог нь тохируулан гарын авлага болгон гаргаж бүх эмч, эмнэлгийн мэргэжилтэн, албан хаагчдад судлуулах	1 сарын 6	Тархвар судлаач С.Өлзийжаргал	НЭМОДарга Б.Лувсанням
<b>Тав. Молекул, биологийн лаборатори байгуулах чиглэлээр:</b>				
22	Молекул, биологийн лаборатори байгуулах өрөө тасалгааг бэлтгэж, стандартын шаардлагад нийцүүлэн засвар үйлчилгээг хийлгэн шаардлагатай тоног төхөөрөмжийг суурилуулж бэлэн болгох	1 сарын 8	Яармаг салбар амбулаторийн эрхлэгч Г.Оюунцэцэг Тархвар судлаач С.Өлзийжаргал	ЭМТөвийн дарга Э.Бодьцэцэг
23	Тус лабораторид ажиллах хүний нөөцийг сургаж дадлагажуулах	1 сарын 4	Хүний нөөцийн албаны дарга Ц.Энхбаясгалан	ЭМТөвийн дарга Э.Бодьцэцэг